



2026 Mar

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ.....1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ.....2

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал.....2

2.2. АНУ-ын эдийн засаг 2026 оны 3-р сард:.....2

2.3. БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 3-р сард:.....3

БНХАУ-ын 15-р таван жилийн төлөвлөгөө батлагдав.....3

2.4. Түүхий эдийн зах зээл.....6

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ7

3.1. Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин.....7

3.2. Улсын төсөв.....9

3.1. Мөнгөний нийлүүлэлт.....10

3.2. Гадаад худалдаа.....11

3.3. Төлбөрийн тэнцэл, ханш13

График, хүснэгтүүдийн жагсаалт

График 1 АНУ-ын инфляц3

График 2 БНХАУ-ын гадаад худалдааны статистик5

График 3 БНХАУ-ын инфляцын түвшин.....6

График 4 Монголын эдийн засгийн өсөлт 2020-20257

График 5 Инфляц ба бодлогын хүү9

График 6 Улсын төсвийн гүйцэтгэл.....9

График 7 Мөнгөний нийлүүлэлт.....10

График 8 Экспорт, импортын өсөлт11

График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн.....11

График 10 Нүүрсний экспортын биет хэмжээ.....12

График 11 Импортын бүтээгдэхүүн13

График 12 Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханш14

Хүснэгт 1 БНХАУ-ын 15-р таван жилийн төлөвлөгөө.....3

Хүснэгт 2 БНХАУ-ын 2026 оны макро эдийн засгийн зорилтууд 4

Хүснэгт 3 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны 1-р сарын урьдчилсан гүйцэтгэл..... 8

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2025Q4	2025Q3	2024Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	34,332	24,251	32,133	6.8%
Ажилгүйдлийн түвшин	%	5.6%	5.5%	5.3%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,878	2,714	2,672	7.7%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M2	2026M1	2026M2	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	3,046	1,749	2,005	51.9%
Зэс	сая ам.доллар	1,404	726	553	153.7%
Нүүрс	сая ам.доллар	1,032	625	859	20.2%
Нийт импорт	сая ам.доллар	1,576	843	1,711	-7.9%
Хэрэглээ	сая ам.доллар	483	250	607	-20.0%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	512	277	582	-12.0%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	170	97	125	35.0%
Шатахуун	сая ам.доллар	408	218	392	4.0%
Тэнцэл	сая ам.доллар	1,471	906	294	4x
Түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	13,344	13,158	9,358	42.6%
Нүүрс (хилийн)	\$/тонн	66.4	64.4	81.3	-18.3%
Алт	\$/трой унц	5,279	4,894	2,858	84.7%
Газрын тос	\$/баррел	72.9	68.6	68.6	6.3%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M2	2026M1	2025M2	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	-720	-425	-566	27.3%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	3,968	1,706	4,024	-1.4%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	4,688	2,131	4,590	2.1%
Мөнгөний бодлого					
M2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	48,146	46,857	41,088	17.2%
ХҮИ (C2023)	индекс	120.7	120.2	113.4	6.5%
Бодлогын хүү	%	12%	12%	10%	
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,566	3,564	3,467	2.9%
Төгрөгийн хадгаламж	%	11.84%	11.66%	11.26%	
Валютын хадгаламж	%	3.41%	3.81%	3.14%	
Төгрөгийн зээл	%	17.26%	17.14%	17.06%	
Валютын зээл	%	10.12%	9.59%	9.36%	
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	6,802	6,738	4,763	42.8%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал

Ойрх Дорнодын мөргөлдөөн

2026 оны 2 сарын 28-нд АНУ болон Израил улс Ираны цэргийн байгууламж, пуужингийн бааз болон цөмийн хөтөлбөртэй холбоотой объектуудад цохилт өгснөөр мөргөлдөөн одоог хүртэлх хугацаанд үргэлжилж байна. Энэ мөргөлдөөнөөс шалтгаалж Ормузын хоолойн тээвэр саатах, улмаар газрын тосны нийлүүлэлт буурч олон улсын зах зээлд газрын тосны үнэ өсөх, тээврийн үнэ өсөх эрсдэл бий боллоо. Ормузын хоолойгоор өдөрт ойролцоогоор 20 бая баррель түүхий нефть болон газрын тосны бүтээгдэхүүн дамжин өнгөрдөг ба тээврийн 80 орчим хувь нь Азийн улс орнууд руу, 20 орчим хувь нь Европын улс руу тээвэрлэгддэг.


Ормузын хоолойг тойрч гарах боломж хязгаарлагдмал, мөн газрын тосны нөөцийн агуулахууд дүүрч байгаа тул Персийн булангийн орнууд нийт олборлолтоо өдөрт дор хаяж 10 сая баррелиар бууруулж байгаа төдийгүй Азийн ихэнх орнууд эрчим хүчний хэрэглээгээ хязгаарлах чиглэлд олон талын арга хэмжээ авч байна. АНУ-ын Батлан хамгаалах яамны зүгээс энэхүү мөргөлдөөн 6-8 долоо хоног буюу 2 сар орчим үргэлжлэх төлөлтэй байгааг дурдсан ба мөргөлдөөн удаан үргэлжилбэл газрын тосны үнэ 100 ам.доллар/баррельд тогтворжиж өсөх эрсдэл байгаа юм.

Монгол улсын хувьд газрын тосны бүтээгдэхүүн нь уул уурхайн, тээврийн болон бусад салбарын гол орц бөгөөд өрхийн хэрэглээний сагсны багагүй хувийг бүрдүүлдэг. Эрчим хүчний үнэ өсөхөд бодит орлого буурч, худалдан авалт багасаж нийт эрэлтийг бууруулснаар эдийн засаг уналт руу шилжих боломжтой. Иймд эдийн засгийн цаашдын төлөвт газрын тосны үнийн өсөлт өндөр түвшинд үргэлжлэн хадгалагдах тохиолдолд 2026 онд эдийн засгийн өсөлт бага байх, бодлогын хүү одоогийн өндөр түвшинд хадгалагдах, өрхийн хэрэглээ, компаниудын санхүү хүнд байдалд орох эрсдэлтэй юм. (Д.Ган-Очир, 2026)

2.2. АНУ-ын эдийн засаг 2026 оны 3-р сард:

2026 оны 3-р сарын 18-нд АНУ-ын Холбооны Нөөцийн Сан бодлогын хүүг 3.5-3.75 хувийн интервалд хэвээр үлдээх шийдвэр гаргасан. Инфляцын түвшин 2-р сард 2.4%-тай гарсан ба инфляцын өсөлтөд орон сууц, эрчим хүчний үнийн өсөлт голчлон нөлөө үзүүллээ. Мөн ажилгүйдлийн түвшин 4.4 орчим хувьтай байгаа нь мөнгөний зөөлөн бодлого явуулах орон зайг хязгаарлаж байна.

График 1 АНУ-ын инфляц



Эх сурвалж: Trading Economics

Ираны мөргөлдөөнтэй холбоотойгоор АНУ-ын хувьд инфляцын эрсдэл нэмэгдсэн ба ХНС-ын зүгээс 2026 оны эхний хагас жил хүртэл мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэх хүлээлттэй байна.

2.3. БНХАУ-ын эдийн засаг 2026 оны 3-р сард:

БНХАУ-ын 15-р таван жилийн төлөвлөгөө батлагдав.

БНХАУ-ын 15 дугаар Таван жилийн төлөвлөгөөний үндсэн баримт бичиг нь 2026 оны 3 дугаар сарын 12-нд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын (БХАТИХ) 14 дэх удаагийн хуралдаан, 4 дүгээр чуулганы хаалтын хуралдаанаар албан ёсоор батлагдсан. 15-р Таван жилийн төлөвлөгөө нь өмнөх жилүүдтэй харьцуулахад өндөр эдийн засгийн өсөлтийн зорилтыг дэвшүүлэхээс илүүтэй чанартай, бүтээмжтэй дотоод эдийн засгийг бэхжүүлэх чиглэлд зорилт тавьсан байна.

Хүснэгт 1 БНХАУ-ын 15-р таван жилийн төлөвлөгөө

5 жилийн төлөвлөгөө 2011-2030 онд	төлөвлөгөөний дараалал (ТОП 3 зорилтууд)
15-р 5 жилийн төлөвлөгөө (2026-2030)	- Орчин үеийн аж үйлдвэрийн системийг хөгжүүлэх - Технологийн бие даасан байдал, инновацийн хөгжлийг хурдасгах - Дотоод эдийн засгийн эрэлтийг нэмэгдүүлэх
14-р 5 жилийн төлөвлөгөө (2021-2025)	- Инновацид суурилсан хөгжлийг бий болгох - Орчин үеийн аж үйлдвэрийн системийг хөгжүүлэх - Дотоод эдийн засгийн эрэлтийг нэмэгдүүлэх
13-р 5 жилийн төлөвлөгөө (2016-2020)	- Инновацид суурилсан хөгжлийг бий болгох - Шинэ хөгжлийн системийг бий болгох - Хөдөө аж ахуйн салбарын шинэчлэлийг хөгжүүлэх

12-р 5 жилийн төлөвлөгөө (2011-2015)	1. Хөдөө аж ахуй болон алслагдсан газруудын хөгжлийг дэмжих 2. Аж үйлдвэрийн салбарын бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэх 3. Үйлчилгээний салбарыг хөгжүүлэх
---	--

Эх сурвалж: Mercator Institute for China studies

БНХАУ эдийн засгийн өсөлтийн зорилтоо 4.5-5.0% болгож бууруулсан ба энэ нь 1991 оноос хойших хамгийн бага үзүүлэлт болж байна. (Brown, 2026) Ийнхүү 2030 он хүртэлх дэвшүүлсэн төлөвлөгөөний зорилтуудыг товч байдлаар дүгнэвэл:

- Уламжлалт хөрөнгө оруулалт, хямд үйлдвэрлэлд түшиглэсэн өсөлтөөс татгалзаж, **инновац, технологи, хүн капитал, ногоон хөгжлийг** эдийн засгийн суурь болгох шилжилтийг хийж эдийн засгийг илүү тогтвортой байх чиглэлийг гол зорилт гэж үзлээ.
- **Технологи, аюулгүй байдлын шинэчлэл:** АНУ-с худалдааны хамаарлаа бууруулж, бие даасан байдлаа хангахын тулд чип, хагас дамжуулагч, квант зэрэг цөмийн зэвсгийн бие даасан байдлаа хангах чиглэлд ажиллана. Мөн геополитикийн эрсдэлтэй байгаа энэ цаг үед батлах хамгаалахын салбарт гаргаж буй зардлаа 7 орчим хувиар нэмэгдүүлж, армийн цэрэгжилт, бэлэн байдлыг 2035 он гэхэд бүрэн шинэчилж сайжруулах зорилт дэвшүүлжээ. Шинжлэх ухаан, хиймэл оюун ухааныг салбар бүрд нэвтрүүлж удирдлагын гол хэрэгсэл болгож байгаа нь стратегийн гол бодлого болж байна.
- **Хүн ам зүйн шинэчлэл:** Хотжилтын түвшин БНХАУ-ын өмнөх 5 жилийн хугацаанд 68 хувьтай байсан ба ирэх 5 жилд 71 хувьд хүргэх зорилттой байна. Мөн хотын ажилгүйдлийн түвшнийг 5.5 хувиас хэтрүүлэхгүй барих, иргэдийн орлогыг ДНБ-ий өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх, төрөлт буурсантай холбоотой хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллана гэсэн зорилттой байна. Ийнхүү томоохон хотуудад 12 сая орчим ажлын байр нэмэгдүүлэх ажлыг эхлүүлж байгааг дурджээ.
- **Инфляцын түвшин** 2025 он гэхэд 0 хувьтай байгаа буюу дефляцтай байгаа бол ирэх жилүүдэд дотоод эрэлтийг төсвийн бодлогоор дэмжин инфляцыг 2 орчим хувьд барих зорилттой байна. Ийнхүү эрэлтийг нэмэгдүүлэхийн тулд төсвийн тэлэх бодлого баримталж байгаа тул **төсвийн алдагдал** нэмэгдэх төлөвтэй байгаа ба алдагдлыг ДНБ-ий 4 хувьд буюу 2025 онтой ижил түвшинд барих шийдвэр гаргасан байна.

Ийнхүү БНХАУ 15-р Таван таван жилийн төлөвлөгөөндөө эдийн засаг, аж үйлдвэрийн шинэчлэл, технологийн инновац, хүрээлэн буй орчны хамгаалал болон нийгмийн эрүүл мэндийн хөгжлийн бодлогыг чухалчилсан хөгжлийн бодлогуудаа зарлалаа. (Huld, 2026)

Хүснэгт 2 БНХАУ-ын 2026 оны макро эдийн засгийн зорилтууд


БНХАУ-ЫН 2026 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ЗОРИЛТОТ ТҮВШИН	
ДНБ-ий өсөлт	4.5 – 5%
Төсвийн алдагдал	4%
Инфляц (ХҮИ)	2%
Хотын ажилгүйдлийн түвшин	5.5%

БНХАУ-ын гол эдийн засгийн үзүүлэлт:

Гадаад худалдаа: БНХАУ-ын гадаад худалдааны гүйцэтгэл өндөр өсөлт үзүүлж 2026 оны 2 сарын байдлаар экспортын өсөлт өмнө жилийн мөн үеэс 21.8%-р, импортын өсөлт 19.8%-р өсөж гадаад худалдааны тэнцэл 213.6 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. Энэхүү өсөлтөд технологийн бүтээгдэхүүний экспорт болон хиймэл оюун ухаанд чиглэсэн хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь голлон нөлөөлөө. Технологийн бүтээгдэхүүний экспортын тал орчим хувийг Азийн зах зээлд, 20 орчим хувийг Европын зах зээлд, үлдсэн хувийг АНУ руу экспортолж байна.

БНХАУ-ын худалдаа ирэх саруудад ч мөн адил өсөлт үзүүлэхээр хүлээгдэж байгаа нь АНУ-ын Дээд шүүхийн тарифын түр чөлөөлөлтийг ашиглан АНУ руу экспортолж буй бараа бүтээгдэхүүний тээврийг хурдасгаж байгаатай холбоотой байна. Геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалж худалдааны хязгаарлалт нэмэгдсэнээр экспортын чиглэлийг Зүүн Өмнөд Ази, Ойрх Дорнод, Африк зэрэг орнууд руу нэмэгдүүлснээр оны эхний гүйцэтгэлд эерэг нөлөөг бий болгожээ.

График 2 БНХАУ-ын гадаад худалдааны статистик



Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний статистикийн хороо

Инфляцын түвшин: 2026 оны эхний 2 сард БНХАУ-ын хэрэглээний үнийн өсөлт нэмэгдэж, ХҮИ 1-р сард жилийн өмнөхөөс 0.2 хувийн өсөлттэй байсан бол 2-р сард Цагаан сарын нөлөөгөөр үйлчилгээ, хүнсний үнийн өсөлт давамгайлан 1.3 хувь болж нэмэгдсэн байна. Харин үйлдвэрийн үнийн индекс 2-р сард -0.9 хувь болж, өсөлтийн хурд саарсан нь үйлдвэрлэлийн түүхий эдүүдийн үнийн өсөлттэй холбоотой байна.

График 3 БНХАУ-ын инфляцын түвшин



Эх сурвалж: БНХАУ-ын үндэсний статистикийн хороо

2.4. Түүхий эдийн зах зээл

Алтны үнэ 2026 оны 2 сард 5,279 ам.долларт хүрч өмнө жилээс 84.7 орчим хувиар өсжээ. 2 сарын сүүлээр Ойрхи Дорнодын асуудал хурцдаж АНУ-ын зүгээс дайралт өгсөн үйл явдал нь алтны үнэ дахин эрчээ авахад нөлөөллөө. Иймд АНУ, Европ зэрэг томоохон улсуудын хувьд мөнгөний хатуу бодлогыг үргэлжлүүлэн барих төлөвтэй байна. Блүүмбэргийн мэдээллийн сан дахь олон улсын байгууллагуудын дундаж үнийн хүлээлтээр 2026 оны эцэст алтны үнэ 4,756 орчим ам.долларт хүрч 2025 оны эцсээс 10 орчим хувиар өсөх төлөвтэй байна.

Зэс: 2026 оны 2 сард зэсийн үнэ 13,344 ам.долларт хүрч өмнө жилийн мөн үеэс 42.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашин, цахилгаан сүлжээний өргөтгөл зэрэг ногоон шилжилтийн хөрөнгө оруулалтууд нэмэгдсэн нь зэсийн эрэлтийг нэмэгдүүлжээ. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул байсан ч дэд бүтэц, эрчим хүч, үйлдвэрлэлийн салбарын эрэлт өндөр байснаар зэс эрэлттэй түүхий эд хэвээр байна. Харин 2026 оны эцэст зэсийн үнэ 12,235 орчимд хүрч өсөлт удаашрах төлөвтэй байна. Нийлүүлэлт талаас зэсийн зах зээлд шинэ томоохон уурхайн нийлүүлэлт хомс, одоо ажиллаж буй гол уурхайнуудын хүдрийн агууламж буурч буй нь үнийг урт хугацаанд дэмжих суурь нөхцөл болж байгаа ч БНХАУ-ын өсөлт болон дэлхийн үйлдвэрлэлийн мөчлөгөөс шалтгаалсан богино хугацааны савлагаа үргэлжлэх төлөвтэй байна.

Газрын тос: 2026 оны 2 сард газрын тосны үнэ 72.9 ам.долларт хүрч өмнө жилээс 6.3 хувиар өссөн байна. 2026 оны 2 сарын 28-нд АНУ-Израиль, Ираны дайнтай холбоотойгоор Ормузын хоолой саатсан нь газрын тосны үнийг богино хугацаанд 40 орчим хувиар нэмэгдүүлсэн. Газрын тосны үнийн ирээдүйн хүлээлт дайн хэр хугацаанд үргэлжлэхээс хамаарах хэдий ч нийлүүлэлт өндөр, эрэлт сул байгаатай холбоотойгоор олон улсын шинжээчдийн зүгээс 2026 оны эцэст үнэ 77 орчим ам.долларт хүрэх хүлээлтийг танилцууллаа. (Bloomberg Terminal)

Нүүрс: 2025 оны 2 сард коксжих нүүрсний хилийн үнэ 66.4 ам.долларт хүрч өмнө жилээс 18.3 хувиар буурчээ. БНХАУ-ын гангийн хэрэглээ буурч, ган үйлдвэрлэгчдийн ашигт ажиллагаа сул байсантай холбоотойгоор үнийн дарамт нэмэгдсэн. 2026 онд коксжих нүүрсний үнэ 70-74 орчим ам.долларт байх төлөвтэй байна. БНХАУ-ын дотоодын олборлолтын өндөр хүчин чадал, гангийн эрэлтийн өсөлт удаашрах, Австралиас нийлүүлэлт нэмэгдэж буй зэрэг хүчин зүйлсүүд үнийн өсөлтийг хязгаарлах хүлээлттэй байна.


III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин

2026 оноос эхлэн Үндэсний Статистикийн Хорооноос эдийн засгийн өсөлтийн урьдчилсан гүйцэтгэлийг сарын давтамжтай гаргадаг болсон. Ийнхүү 2026 оны 1-р сард Монгол улсын бодит ДНБ (2015 оны сууриар тооцсон) өмнөх оны мөн үеэс 8.6%, харин өмнөх сараас 0.8%-аар өсжээ.

Ийнхүү эдийн засаг өндөр өсөлттэй гарахад өмнөх оны мөн үеэс уул уурхайн, олборлолтын салбар 33.2%-аар, үйлчилгээний салбар 4.3%-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Гадаад худалдааны нөхцөл байдал үргэлжлэн сайжирч байгаатай холбоотойгоор 1-р сарын нүүрсний олборлолт өмнөх оны мөн үеэс 55.7%-аар, мөн Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэлийн хүрээнд зэсийн баяжмал 32.6%-аар өссөн нь уул уурхайн салбарын өндөр өсөлтийг ийнхүү тэтгэжээ.

График 4 Монголын эдийн засгийн өсөлт 2020-2025



Харин эдийн засгийн өсөлтийг салбарын оролцооны хувиар ангилж харвал, нийт өсөлтийн 5.5 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар бүрдүүлсэн бол 2.4 нэгж хувийг үйлчилгээний салбар, харин 0.8 нэгж хувийг үйлдвэрлэл, барилгын салбар бүрдүүлжээ.

Хөдөө аж ахуйн салбар 2026 оны 1-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 11.0%-аар өссөн нь нийт эдийн засгийн өсөлтөд 0.2 нэгж хувийн нөлөөлөл үзүүлж байна. 2025 оны 1-р

сард хөдөө аж ахуйн салбар 32.6 хувийн өсөлттэй байсантай харьцуулахад тус салбарын өсөлтийн хурд ийнхүү саарч, харьцангуй тогтворжиж эхэлжээ.

Цаашлаад бүтээгдэхүүний цэвэр татвар эдийн засгийн өсөлтөд 0.3 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.8 нэгж хувиар буурахад онцгой албан татвар 50.3%-аар, импортын барааны НӨАТ 11.9%-аар буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 3 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны 1-р сарын урьдчилсан гүйцэтгэл

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	8.6%	
ХАА	0.2%	11.0%
Уул уурхай, олборлолт	5.5%	33.2%
Үйлдвэрлэл, барилга	0.8%	5.4%
Үйлчилгээ	2.4%	4.2%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-0.3%	-2.8%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны хоёрдугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5%, өмнөх сараас 0.5%-аар өслөө. Мөнгөний бодлогын хатуу төлөв үргэлжилж, ийнхүү сүүлийн гурван сар дараалан инфляц Төв банкны зорилтод интервалд хадгалагдан буурсан бөгөөд цахилгааны үнийн өсөлтийн суурь нөлөө арилсан нь өмнөх оны мөн үеэс хурдац саарахад голлон нөлөөлөв.

Жилийн инфляцыг барааны бүлгээр задлан авч үзвэл хүнсний бараа, ундаа, усны үнэ болон боловсролын үйлчилгээ хамгийн өндөр буюу өмнө оны мөн үеэс тус тус 12.3% болон 12.8%-аар өсжээ. Мөн үнийн өсөлтийг оролцооны хувиар авч үзэхэд 3.3 нэгж хувийг хүнсний инфляц бүрдүүлсэн бөгөөд үүнд мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, 2026 оны 2-р сард үхрийн махны үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.4%-иар, хонь, ямааны махны үнэ 16.7%-иар тус тус өсжээ. Түүнчлэн зэс, алтны экспортын орлого хүлээгдэж байснаас өндөр гарсан нь төлбөрийн тэнцэл, гадаад валютын ханшид эергээр нөлөөлж, импортын гаралтай инфляцын нөлөө сүүлийн саруудад буурлаа. Өөрөөр хэлбэл, энэ оны 2-р сард инфляц 6.5 хувь гарсны 1.4 нэгж хувийг импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

График 5 Инфляц ба бодлогын хүү



Хэдийгээр төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнийн өсөлтийн суурь нөлөө арилж инфляц Монголбанкны зорилтот интервал руу буурах хандлагатай байгаа ч энэ онд нэмэгдүүлэхээр төлөвлөсөн эмч, багш нарын цалингийн өсөлт болон хүнс, шатахууны үнийн өсөлтийн нөлөөгөөр эргэн эрчимжих эрсдэл өндөр байна.

3.2. Улсын төсөв

Улсын төсвийн зардал 2026 оны 2-р сард 4.7 их наяд төгрөг болж өмнөх оноос 2.1%-аар өссөн бол тэнцвэржүүлсэн орлого 1.4%-аар буурч 4.0 их наяд төгрөгт хүрлээ. 2026 оны 2-р сард улсын төсвийн зардлын 44.6% нь урсгал шилжүүлэг, 33.1% нь бараа үйлчилгээний зардал, 12.3%-ийг хүүгийн зардал бүрдүүлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төсвийн зардал 2.1%-иар буюу 98.2 тэрбум төгрөгөөр өсөхөд хөрөнгийн зардал 13.2%-иар, бараа үйлчилгээний зардал 5.8%-иар, бусад урсгал шилжүүлэг 10.6%-иар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Ийнхүү төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026 оны 2-р сарын байдлаар 0.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарав.


График 6 Улсын төсвийн гүйцэтгэл



3.3. Мөнгөний нийлүүлэлт

2026 оны 2-р сард мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.2%-аар өсөж 48.1 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр (пассив) талаас иргэд болон байгууллагын хадгаламж өссөн нь голлон нөлөөлсөн бол гадаад валютын харилцах өмнөх оноос буурсан нь сөргөөр нөлөөлжээ. Тухайлбал, төгрөгийн хадгаламж энэ оны 2-р сард 26.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 4.4 их наяд төгрөг буюу 19.9%-иар, валютын хадгаламж 5.3 их наяд төгрөгт хүрч 11.8%-иар өссөн бол валютын харилцах 1.6 их наяд төгрөгөөр буюу 43.4%-иар буурч 2.1 их наяд төгрөгт хүрсэн байна. Төгрөгийн хадгаламжийн 82.8%-ийг иргэдийн хадгаламж, 17.2 хувийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.

График 7 Мөнгөний нийлүүлэлт




Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд байршуулалт (актив) талаас гадаад валютын цэвэр орох урсгал сайжирч, банкны системийн гадаад цэвэр активын өсөлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, гадаад цэвэр актив 2026 оны 2 дугаар сард 10.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 4.6 их наяд төгрөгөөр буюу 81.5%-иар өссөн байна. Түүнчлэн зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдсан нь дотоод цэвэр активыг нэмэгдүүлж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд эергээр нөлөөлжээ.

3.4. Гадаад худалдаа


2026 оны 2-р сарын гүйцэтгэлээр нийт импорт 1,576 сая ам.долларт хүрсэн бол нийт экспорт 3,046 сая ам.долларыг давж гадаад худалдааны тэнцэл 1,471 сая ам.долларын ашигтай буюу өмнөх оны мөн үеэс 5 дахин өсжээ.

График 8 Экспорт, импортын өсөлт



Ийнхүү 2026 оны 2-р сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 52%-аар өсөхөд зэсийн экспортын орлого 2.5 дахин, харин нүүрсний экспортын орлого 20.2%-аар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

График 9 Экспортын голлох бүтээгдэхүүний орлого-2026 2 сар,



Оюутолгой далд уурхай 2023 оноос ашиглалтад орсонтой холбоотойгоор зэсийн экспортын орлого тасралтгүй өсөж 2025 оны дундаас экспортын тэргүүлэх түүхий эд

болоод буй. Мөн Оюутолгой ХХК-ийн төсөөллөөр цэвэр зэсийн үйлдвэрлэл 2028-2036 онуудад 500 мянган тонн-д хүрэх тооцоололтой байна (2024 онд 142 мянган цэвэр зэсийг үйлдвэрлэж байсан бол 2025 онд үйлдвэрлэл 61%-аар өсчээ, Оюутолгой 2026)

2026 он гарснаас хойш зэсийн экспортын орлого үргэлжлэн өсөж эхний хоёр сарын байдлаар нийт орлогын 46.1%-ийг дангаар бүрдүүлж байгаа бол нүүрсний орлого 33.9%-ийг бүрдүүлж байна.


График 10 Нүүрсний экспортын биет хэмжээ



2025 оны 8-р сараас эхлэн БНХАУ-ын дотоод хэт үйлдвэрлэл, олборлолтыг бууруулах бодлогын үр дүнд нүүрсний хилийн үнийн огцом бууралт зогсож эргэн сэргэж эхэлсэн. Тухайлбал 2025 оны 8-р сард сарын цэвэр чулуун нүүрсний хилийн үнэ тонн тутамд 56.8 ам.долларт хүрч буураад байсан бол түүнээс хойш аажмаар өсөж 2026 оны 2-р сарын байдлаар тонн тутамд 66.4 ам.долларт хүрсэн байна. Мөн Монгол Улсын Засгийн Газраас боомтын сэргэлтийн ажлыг үргэлжлүүлэх хүрээнд төмөр замын холболтын ажлыг үе шаттайгаар хийж байгаа бөгөөд улмаар нүүрсний экспортлох биет хэмжээ өсөж 2026 оны эхний хоёр сарын гүйцэтгэлээр нийт 15.8 сая тонн нүүрс экспортолсон нь өмнө жилийн 10.3 сая тонноос 53.4%-аар өссөн үзүүлэлт болж байна.

Импортын голлох бүтээгдэхүүний зардал-2026 2 сар

жилийн өсөлт, зардлын хэмжээ



Эх сурвалж: Монголбанк

Дотоод эрэлтийн идэвхжил өмнө оноос суларч импортын зардал буурав. Тухайлбал 2026 оны 2-р сарын байдлаар нийт импортын зардал өмнөх оны мөн үеэс 135 сая ам.доллараар буюу 7.9%-аар буурч 1.6 тэрбум ам.долларт хүрчээ.


Импортыг голлох бараагаар задлан авч үзэхэд нефт, шатахууны бүтээгдэхүүний импорт нийт зардлын 25.9%-ийг бүрдүүлж өмнө оны мөн үетэй харьцуулахад 4%-ийн өсөлттэй гарсан бол бусад бүтээгдэхүүний импорт тэр дундаа суудлын болон ачааны автомашины импортын зардал дунджаар 41.4%-аар буурчээ.

3.5. Төлбөрийн тэнцэл, ханш

Ийнхүү сүүлийн саруудад экспортын өсөлт өндөр, харин эсрэгээрээ импортын зардал буурч байгаа нь урсгал дансны алдагдлыг бууруулж, өмнөх оны мөн үеэс төлбөрийн тэнцлийн алдагдал буурахад нөлөөлж байна.

2026 оны 1-р сарын гүйцэтгэлээр урсгал данс 445 сая ам.долларын ашигтай гарсан бол санхүүгийн данс 539 сая ам.долларын алдагдалтай гарсан бөгөөд төлбөрийн тэнцэл 489 сая ам.долларын алдагдалтай гарчээ. Засгийн газрын зүгээс 2026 оны 3-р сарын 5-нд 500 сая ам.долларын хэмжээтэй, 5.95%-ийн хүүтэй Сенчири-5 бондыг олон улсын зах зээлд амжилттай арилжаалсан нь санхүүгийн дансаар орж ирэх валютын урсгалыг нэмэгдүүлж төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөхөөр байна.

График 12 Төлбөрийн тэнцэл, ГВАН, ханш



Эх сурвалж: Монголбанк

2026 оны 2-р сарын байдлаар гадаад валютын албан нөөц (ГВАН) 6.8 тэрбум ам.доллар буюу дунджаар 8 сарын импортыг хангах хэмжээнд байна. Энэ нь өмнөх оны мөн үеийн 4.8 тэрбум ам.доллараас даруй 42.8%-аар, харин өмнөх сараас 64 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү валютын нөөц тогтвортой өндөр хэмжээнд хадгалагдаж, ханшийн хэлбэлзэл харьцангуй тогтвортой буюу 2-р сарын эцэст нэг ам.доллар 3,566 төгрөгтэй тэнцэж байгаа нь төгрөгийн нэрлэсэн ханш 2025 оны эцсээс 0.2%-аар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1%-аар суларсан үзүүлэлт болж байна.

2026 оны 3-р сараас Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдал, ялангуяа АНУ, Израил-Ираны хоорондын мөргөлдөөн хурцдах, Ормузын хоолой хэсэгчлэн хаагдах, газрын тосны нийлүүлэлтийн сүлжээ тасалдах зэргээс шалтгаалж нефтийн бүтээгдэхүүний импортын зардал өсөх, мөн гадаад инфляц өдөөгдсөнөөр импортын барааны үнэ өсөх, улмаар инфляц хөөрөгдөх, ханш хэлбэлзэх эрсдэлтэй. Олон улсын судалгааны байгууллагууд болон дотоодын томоохон эдийн засагчдын дүгнэлтээр брент газрын тосны үнэ 100 ам.долларыг давж (суурь түвшнээс 40%-аар хөөрөгдөх) өсөх хүлээлттэй ба ийнхүү өсөх нь Монгол улсад нийлүүлэлтийн болон эрэлтийн шокоор дамжиж эдийн засгийн өсөлтийг суурь түвшнээс 1.9 нэгж хувиар бууруулах, инфляцыг 1.4 нэгж хувиар өсгөх, ханшийг 3.6 нэгж хувиар нэмж сулруулах нөлөөлөлтэй байна. (Д.Ган-Очир, 2026)



ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

☎ 7575-1111 /1277/
✉ eru@golomtbank.com
🌐 www.dua.golomtbank.com

📍 Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.